



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 117

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 77.3 дахь хэсэг, аймгийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг: “Дундговь ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн нийт 145,862,600 (нэг зуун дөчин таван сая найман зуун жаран хоёр мянга зургаан зуу) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Дундговь Ус” ОНӨҮГазарт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: “Дундговь ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга Д.Ганбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100286

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 оны 12 сарын 10-ний өдрийн  
117 дугаар тогтоолын хавсралт



“Дундговь ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэх  
хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр төрөл	х/нэгж	тоо/ш	нэгж үнэ	Нийт дүн
1	1-р УТБайрны хашаа	М2	66	18,000.00	1,188,000.00
2	7-р УТБайрны хашаа	М2	66	18,000.00	1,188,000.00
3	16-р УТБайрны хашаа	М2	66	18,000.00	1,188,000.00
4	7-р УТ Синдвичин байр	ш	1	3,932,800.00	3,932,800.00
5	1-р УТ Синдвичин байр	ш	1	3,932,800.00	3,932,800.00
<b>Барилга байгууламжийн дүн</b>					<b>11,429,600.00</b>
1	УТБайрны Удирдлагын платпорм	ш	3	4,065,000	12,195,000
2	Карт уншигч	ш	3	300,000	900,000
3	Хянах дэлгэц /хяналтын программ хангамжтай	ш	3	1,230,000	3,690,000
4	Цахилгаан тоолуур /УХ/	ш	3	310,000	930,000
5	Серверийн суурин компьютер /программ хангамжтай/	ш	1	6,120,000	6,120,000
6	Тог баригч	ш	1	510,000	510,000
7	Хяналтын дэлгэц /камерын/	ш	1	810,000	810,000
8	380 вт-ийн 100А тоолуур	ш	4	400,000	1,600,000
9	Гүний насос 15 квт /6001/	ш	1	2,400,000	2,400,000
10	Гүний насос 11 квт /6003/	ш	1	2,800,000	2,800,000
11	Уурын зуухны тогоо	ш	1	74,400,000	74,400,000
12	Samsung U2 ugj utas /слесариудад/	ш	2	420,000	840,000
13	Dell компьютер /сэргэлэнд/	ш	1	1,450,000	1,450,000
14	Насос /уурын зуух/	ш	1	1,870,000	1,870,000

15	UV/ Visible Спектрофотометр	ш	1	13,360,000	13,360,000
16	Усан ванн /лаборатори/	ш	1	425,000	425,000
17	Вакум насос /лаборатори/	ш	1	745,000	745,000
18	Кондуктометр /лаборатори/	ш	1	3,768,000	3,768,000
19	Шүүх төхөөрөмж /шилний наалт/	ш	1	765,000	765,000
20	Термостат /лаборатори/	ш	1	945,000	945,000
21	Автоклав DSX-280A /лаборатори/	ш	1	685,000	685,000
22	Автоклав В Class /лаборатори/	ш	1	3,225,000	3,225,000
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>					<b>134,433,000</b>
<b>Нийт дүн</b>					<b>145,862,600</b> (нэг зуун дөчин таван мянга найман зуун жаран хоёр мянга зургаан зуу)